



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/20

Хажуу шалгагч

Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6, Орон нутгийн Хөгжлийн сангийн ажлын хэсгийн 2023 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах" 16,700,000.00 (Арван зургаан сая долоон зуун мянга) төгрөгийн үнийн санал ирүүлсэн С.Эрдэнэмөнх ахлагчтай "Олны хүч" иргэний бүлэгтэй шууд гэрээ байгуулах эрхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д олгосугай.

2. Хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг захиалагчийн гаргасан саналд үндэслэн чанар сайтай хийж гүйцэтгэхийг "Олны хүч" иргэний бүлгийн ахлагч (С.Эрдэнэмөнх)-д даалгасугай.

3. С.Эрдэнэмөнхтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Санхүү албаны дарга (Н.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ТАРИУНАА